

У. Б. Баркманн, Монгол Улсын Их Сургууль  
(Улаанбаатар, Монгол Улс)

## CHANGE BY EXCHANGE БУЮУ ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛИЙГ ӨРГӨН СОЛИЛЦООГООР

Герман-Монголын шинжлэх ухааны  
харилцаанд Германы Эрдмийн Солилцооны  
Алба (ДААД)-ны гүйцэтгэж буй үүрэг

Герман, Монгол хоёр улсын шинжлэх ухааны харилцаа бүр өнгөрсөн зууны 20-иод оноос эхтэйг хүмүүс тэр болгон мэддэггүй. Уг эхлэл тухайн үеийн Монгол Улсын Засгийн газар улс орноо Зөвлөлт Холбоот Улсын төмөр бахь мэт шахалт хавчилтаас гаргах гэж эрмэлзэж байсантай нягт холбоотой байв. Ерөнхий сайд Б. Цэрэндоржийн толгойлж байсан Засгийн газар яагаад чухамхүү Герман орныг өөрсдийн үлгэр дуурайл, байж болох түншээ хэмээн үзсэнийг зөвхөн таамаглаж л болох агаад Оросоос ирсэн буриад сэхээтнүүд Монгол Улсын нам, төрийн удирдлагад ийм бодол төрүүлсэн байж ч магадгүй. Тухайлбал, эдгээр сэхээтэн нар Монгол Улсын анхны Үндсэн хуулийг зохиохдоо эхэн үедээ Германы Үндсэн хуулийг баримтлах санаа агуулж байсан билээ.

Түүнээс гадна тэр үеийн Зөвлөлт Холбоот Улс, Германы харилцаа хүмүүсийн бодлогоос дээр байсан бөгөөд энэ нь Монгол Улсыг Германтай өргөн харилцаа тогтооход зөвлөлтийнхөн төдий л дургүйцэхгүй биз гэсэн итгэл найдварыг төрүүлж байсан хэрэг. Ямар ч байсан Ерөнхий сайд Б. Цэрэндорж 1924 оны 11-р сарын 3-нд Москвад суухаар шинээр томилогдсон Монголын Элчин сайд А. (Япон) Данзанд хэрхэн ажиллах тухай удирдамжаа өгөхдөө:

"Элчин сайд та Москва хотод сууж буй гадаад улсын элчин сайдууд ... тусгайлан Герман Улсын Элчин сайдад эрхиш биеэр учирч ... басхүү манай Монголын тухай элдэв ном дэвтэр гаргаж буй хэмээх эрдэмтэн нар лугаа

учирч танилцан, байдал учрыг нэвтрэлцэж, түүний ямар бодлоготой ба зохиосон ном дэвтрийг олж авч ирвэл зохино”<sup>1</sup> хэмээн зааварчилж байжээ.

Үүнийхээ дараагаар Монгол Улс 1926 онд 31 сурагч, оюутныг Германд сургахаар илгээсэн юм. Эсрэгээр, Монголын анхны үйлдвэрүүдийг байгуулахад туслахаар Германы инженер, техникийн ажилтнууд мөн тус оронд хүрэлцэн ирсэн байна. Германы эрдэмтэд ч бас Монголыг зорьжээ. Тухайлбал, Германы алдарт хятадач болон монголч эрдэмтэн Э. Хэниш хожмын Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн түрүү үеийн байгууллага болох Судар Бичгийн Хүрээлэнгийн нөхөдтэйгөө хамтран судалгааны ажил хийхээр 1928 онд Улаанбаатарт ирж байв.

Монголын сурагч, оюутнууд 1929-30-аад онд улс төрийн нөхцөл байдалд шахагдан эх орондоо буцахаас өөр аргагүй болсон ч Германд байхдаа сурч мэдсэн, дадал заншил болгосон, хайрласан бүхнээ “тээшиндээ” хамт авч ирсэн билээ. Үндэсний их зохиолч Д. Нацагдорж бичгийн ширээн дээрээ Брокхаусын их нэвтэрхий толийг байнга байлгадаг байсан бол хожмын Ардын зураач Л. Намхайцэрэн Улаанбаатарт буцаж ирснийхээ дараа, салахдаа герман багшийнхаа бэлэглэсэн хийл хөгжмөөр концерт тоглож байжээ. Мөн Ш. Цэвэг сталинист харгислалын хар сүүдэр “герман оюутнууд”-ын дээрээс хэдийн нөмрөөд байсан 30-аад онд монгол-герман толио зохиож эхлээд байв.

БНАГУ, Монгол Улс хоёр шинжлэх ухаан, соёлын салбарт хамтран ажиллаад ирмэгц шинжлэх ухааны хамтын ажиллагаанд оролцож буй германчууд хийгээд монголчууд тэр үеийн үзэл суртлын нөлөөнөөс ангид байж, маш богино хугацаанд бие биеэ хайрлан хүндэтгэх болсон юм. БНАГУ 1976 оны орчимд өөрийн орны их, дээд сургуулиудад суралцах оюутнуудад зориулан Монгол Улсын Их Сургуулийн Хэлний бэлтгэл факультетэд нэг жилийн герман хэлний анги нээжээ. Лайпциг хотын Хердерийн хүрээлэн энэ зорилгоор ахлах лектороор толгойлуулсан 3 лектор-багшийг Улаанбаатар руу илгээсэн ба уг бүрэлдэхүүн жил бүр 60-80 оюутанд

1 U. B. Barkmann, L. Chajsandai, Mongolisch-deutsche Beziehungen. Vergangenheit-Gegenwart-Perspektiven, Ulaanbaatar 2004, 229-230-р тал

герман хэл зааж байв. Багш нар хичээлийн хөтөлбөрөө өөрсдөө боловсруулж, сургалтын материалаа бэлтгэн шалгалт аваад, төгсөгчдөд гэрчилгээ олгодог байлаа. Ингээд монгол төгсөгчдөөс чухам хэнийг БНАГУ-д явуулан сургахыг тэд л шийддэг байжээ.

Харин БНАГУ-д суралцсан оюутнууд тэндээ соёлын янз бүрийн нөлөөнд автах нь элбэг. Тухайлбал, Ваймарт сурлаа гэхэд Гёте, Шиллер нартай ихээхэн ойртон холбогдоно. Ийм маягаар Гётегийн "Фауст", Шиллерийн "Хар санаа, хайр сэтгэл"-ийн одоо бараг мартагдаад буй монгол орчуулгууд үүссэн байдаг юм. Потсдамд сурлаа гэхэд Их Фридрих ч юмуу, Сансоссийн шилтгээнтэй танилцаад авна. Тэгвэл Дрезденд сурсан хүн тун удалгүй "Эльбагийн Флоренц" хэмээгдэх энэ хотын дэлхийд алдартай урлагийн бүтээлийн цуглуулгуудыг мэддэг болсон байх жишээтэй. Монгол оюутнууд эхлээд бүгд нэг жил Лайпцигийн Хердерийн хүрээлэнд хэлний бэлтгэл хийнэ. Тийм учраас Лайпцигийн "Гевандхаус" найрал хөгжмийг мэдэхгүй хүн тэдний дунд бараг байдаггүй. Зарим нэг нь 20-иод оны Л. Намхайцэрэн шиг номын эх орон Германдаа очсон хойноо сонгодог хөгжимд дуртай болсон ч юм билүү. Мөн монгол оюутнууд тухайн үедээ герман найз нартайгаа хамтран өрнөдийн хөгжмийн аянд бүжиглэж, өрнөдийн маягаар хувцаслаж, социализмын сайн муугийн талаар маргалдан, Берлин хот хийгээд хүмүүсийн толгойд байсан хана хэрмэнд улам бүр дургүйцэх болж, өрнөдийн телевиз үзсэнээр Монголд буцаж ирсэн хойноо өөрийн орны улс төрийн тогтолцоонд шүүмжлэлтэй хандан, учрыг нь олоход түлхэц өгч байсныг мартаж болохгүй.

ДААД-ын тооцоолсноор 1989 он хүртэл 530 орчим монголчууд БНАГУ-д их, дээд сургууль төгсчээ.<sup>2</sup> Эдгээр төгсөгчид эх орондоо эргэн ирсний дараа юуны өмнө шинжлэх ухаан, аж ахуй, засаг захиргааны салбарт ажилласан байна. БНАГУ нийтдээ 20.000 орчим монголчуудыг дээд, тусгай мэргэжлийн дунд болон техник мэргэжлийн сургуулиудад сургасан гэдэг. Улс төрийн шинэчлэл хийгдсэн 1990 оны үед Монголын хүн ам 2,153 сая орчим байсан гэж бодоход хүн амын нэг хувь нь герман хэл мэддэг байжээ. Герман хэл тэгэхээр хэлнийхээ хувьд 1990 онд өрнөд рүү гарах анхны гарц байсан гэхэд болно. Тэр үед Герман улс

2 DAAD's cooperation with Mongolia, 1997, ДААД-ын архив, Бонн.

монголчуудын мэдэх цорын ганц өрнөдийн орон болохынхоо хувьд Монгол Улсын цаашдын хөгжлийн замд хамгийн чухал үлгэр жишээ болсныг гайхах зүйлгүй. Энэ бүхэн, хожмоо Германы нэгэн дипломатчийн үнэлсэнчлэн, “монголчууд БНАГУ-ын тус оронд үлдээсэн найрамдал, итгэлийн капиталыг ... 1990 оны дараа нэгдсэн Герман улсад төвөггүйхэн дамжуулж чадсан”-ы гол үндэс болсон нь лавтай.<sup>3</sup>

ХБНГУ-ын анхны Элчин сайд доктор Р. Холубек Монголд үйл ажиллагаагаа эхэлж байхдаа засаг захиргааны бүхий л түвшинд германаар ус цас шиг ярьдаг түншүүдтэй тааралддаг байснаа дурссан байдаг. Энэ нь шаардлагатай ажил хэргийн хэлхээ холбоог түргэн зуур тогтоож, ойрын хугацаанд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны алхмуудынхаа талаар ойлголцох боломжийг түүнд олгож байжээ.

Шинжлэх ухаан, дээд боловсролын салбарт хамтран ажиллахын үндсийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хооронд 1986 оны 6-р сарын 12-нд байгуулсан “Соёлын хамтын ажиллагааны Хэлэлцээр”-ээр бүр олон жилийн өмнө тавьсан байв. Уг хэлэлцээрт Шинжлэх Ухааны Академиуд, дээд сургуулиуд болон дээд боловсролын бусад байгууллагуудын харилцааг идэвхжүүлэх, эрдэмтэд, оюутнууд солилцох, тэрчлэн сургалт, судалгааны ажлаар явагсдад тэтгэлэг олгохоор заажээ.<sup>4</sup> Эрдэмтэд, оюутнууд солилцох тухай энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг хэрэгжүүлэх үүднээс ДААД 1989 оны 8-р сарын 28-нд тодорхой хэмжээний тэтгэлэг олгох саналыг Монголын талд тавьсан юм.

Германы урьдаа барьдаг монголч эрдэмтэд – Вальтер Хайссиг, Клаудиус Ц. Мюллер нарын санаачлан зохион байгуулсан “Ди Монголень” (“Монголчууд”) үзэсгэлэн 1989 оны 5-р сарын 22-28-ны хооронд Мюнхений Урлагийн Ордонд гарсан нь Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Монгол Улсын хоорондын соёл, шинжлэх ухааны харилцаан дахь анхны томоохон үйл явдал

3 Deutsche Botschaft Ulaanbaatar, Kulturpolitischer Jahresbericht 1995, ДААД-ын архив, Бонн.

4 Udo B. Barkmann (Hrsg.), Verträge und Abkommen zwischen der Bundesrepublik Deutschland und der Mongolei, Ulaanbaatar 2005, 1-3-р тал.

болсон нь эргэлзээгүй. Үзэсгэлэнгийн хоёр боть товъёг<sup>5</sup> ДААД-аас тэтгэлэг хүртсэн Германы монголч эрдэмтэд ч бас Монголын түүх, угсаатны зүй, шашны талаар хийсэн судалгааныхаа үр дүнг танилцуулсан өгүүллүүд нийтлүүлжээ. Олон хүн ирж үзсэн уг үзэсгэлэн Германы хүн амын дотор Монголыг сонирхох сонирхлыг төрүүлсний зэрэгцээ Монгол орныг Европт танилцуулахад зохих хувь нэмрээ оруулсан билээ.

Хоёр Герман нэгдэхийн өмнөхөн БНАГУ-ын зүгээс БНМАУ-д үзүүлсэн хөгжлийн туслалцааг бүртгэн шалгах, нэгдсэн Герман улсаас хөгжлийн бодлогын хүрээнд Монголтой хамтран ажиллах чиглэлийг тогтоох зорилгоор ХБНГУ, БНАГУ-ын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдсэн холимог ажлын хэсэг Монголд ирэхэд энэхүү өгүүллийг бичигч түүний бүрэлдэхүүнд орсон юм. Төлөөлөгчид үүнтэй холбогдуулан шинжлэх ухааны салбарт цаашид хамтран ажиллах чиг шугамыг тодорхойлохын тулд БНАГУ, Монгол Улсын хоорондох дээрх салбарын хамтын ажиллагааны статусыг мөн шалгасан болно. Бид бас тэр үеийн Шинжлэх ухаан, Боловсролын яамны сайд Н. Уртнасантай уулзаж, тэтгэлэг, сургалтын хөтөлбөрийн асуудлаар санал солилцсон бөгөөд БНАГУ Монголоос жил бүр 50 оюутан их, дээд сургуульд, 30 оюутан тусгай мэргэжлийн дунд сургуульд сургаж байсан тухай сайд ярьж билээ. Германы их, дээд сургуулиудад мөн жилээс жилд 10 орчим хүн эрдмийн зэрэг горилсон бүтээл дээр ажиллаж байжээ. Оюутнууд болон эрдмийн зэрэг горилогчдыг сургах зардлыг БНАГУ-ын Засгийн газар бүхэлд нь хариуцаж байв. Германы төлөөлөгчид Шинжлэх ухаан, боловсролын сайдтай уулзахдаа: “Хоёр Герман нэгдсэний улмаас монгол оюутнуудад ямар нэг хохирол учрахгүй, тэд цааш үргэлжлүүлэн суралцах бөгөөд харин дээд боловсролын салбарт ирээдүйд нэгдсэн Германы зүгээс үзүүлэх тусламжийн талаар ярилцах шаардлагатай байгаа” гэсэн юм.<sup>6</sup>

Хоёр Герман нэгдсэний дараа Гадаад Хэргийн Газрын зөвлөсний дагуу Зүүн Германы их, дээд сургуулиудад сурч буй монгол оюутнуудыг ДААД ивээлдээ авснаар уг байгууллагын Берлин-

5 Die Mongolen, I, II, Innsbruck, Frankfurt a. Main 1989.

6 Abschlussbericht über die Dienstreise einer Arbeitsgruppe in die Mongolische Volksrepublik (11.-22. September 1990), Bonn, den 28.09.1990.

Митте (Төв Берлин) дэхь салбар Зүүн Германд байгаа Монголын 150 орчим оюутныг хариуцах боллоо. Хожим нь эдгээр оюутны 85 орчим хувь сургуулиа амжилттай төгсчээ. Энэ нь уг оюутнуудын идэвх зүтгэлийн зэрэгцээ ДААД тэднийг харж хандах үүргээ чанартай биелүүлснийг харуулсан хэрэг болсон юм.

ДААД 1990 ондоо багтаан анхныхаа лектор-багш, доктор Б.-М. Линкег Улаанбаатар хотын Монгол Улсын Их Сургуульд илгээв. Элчин сайд Р. Холубек тэр даруй доктор Б.-М. Линкег дагуулан Монгол Улсын Их Сургуулийн ректор Д. Доржтой уулзахаа мартсангүй. Тэрхүү уулзалтын үеэр Р. Холубек, ХБНГУ-ын Засгийн газар ДААД-ын шугамаар ийм хурдан лектор-багш ирүүлж байгаа нь хуучин БНАГУ-аас Монгол Улстай тогтоосон онцгой найрсаг харилцааг аль болох өргөн хүрээнд үргэлжлүүлэх гэсэн хүсэл эрмэлзлийнх нь илэрхийлэл юм хэмээн мэдэгджээ. <sup>7</sup> Монголд ирж ажиллахаар бэлтгэж байх үедээ мөн БНАГУ-ын сүүлчийн ахлах лектор Освальдтай уулзан ярилцсан Линке Улаанбаатарт хүрэлцэн ирснийхээ дараа “БНАГУ-ын соёлын эрчимтэй үйл ажиллагаа ихээхэн үр дүнтэй” байсныг нүдээр үзсэн ба энэ тухайгаа тэрбээр:

“герман хэл нэгдүгээрт, соёл, шинжлэх ухааны хэл гэдэг утгаараа энд англи, францаас хамаагүй илүү хэрэглэгдэж байна ... хоёрдугаарт, өдөр тутмын амьдралд ч ихээхэн нэвтэрсэн бөгөөд герман хэл ойролцоогоор ч гэсэн ийм өндөр байр суурь эзэлдэг өөр орон ямар ч байсан бүхэл бүтэн Ази тивд л лав байхгүй гэхэд хэтрүүлсэн болохгүй. Ийм нөхцөлд, энэхүү туйлын таатай бааз суурийг цаашдынхаа үйл ажиллагаанд, ирээдүйн хэлхээ холбоогоо бэхжүүлэхэд ашиглахгүй байх аваас бидний хувьд тун хариуцлагагүй зүйл болох билээ” хэмээн үнэлсэн байдаг. <sup>8</sup>

Гэвч Линке Монгол Улсын Их Сургууль дээр ирсэн хойноо Германд байхад нь хэн ч хэлж сануулж байгаагүй нэг зүйл болох хаана ажиллах вэ, Хэлний Бэлтгэл факультетэд үү, эсвэл Гадаад Хэлний Дээд Сургуульд уу гэдэг асуудалтай тулгарчээ.

7 В.-М. Linke, Gesprächsnotiz, 28.02.1991, ДААД-ын архив, Бонн.

8 Jahresbericht 1991, Lektorat Staatsuniversität Ulan Bator, Mongolische Volksrepublik, Dr. Bernd-Michael Linke, ДААД-ын архив, Бонн.

Хэлний Бэлтгэл факультет түүний ирснийг, нэгдсэн Герман улс уг факультетийн төгсөгчдийг хуучин БНАГУ-ын адил тэтгэж, анхдагч сургалтанд хамруулах нь хэмээн ойлгож байлаа. Харамсалтай нь Холбооны Бүгд Найрамдах Герман улсын шинжлэх ухааны хамтын ажиллагааг тэтгэх тогтолцоо огт өөр бүтэц, нөхцөл болзолтой тул энэ нь бүтэшгүй зүйл болжээ. Линкед хичнээн эвгүй байлаа ч гэсэн Герман улс эдгээр төгсөгчдийг хүлээн авахгүй гэдгийг монгол түншүүддээ тайлбарлахаас өөр арга байсангүй. Иймээс ч тэрээр илтгэлдээ:

“... нэгдсэн шинэ Герман улс хуучин БНАГУ шиг жил бүр 60 оюутанд тэтгэлэг олгох боломжгүй гэдэг яриа оюутнуудын дунд яг л түймрийн гал мэт тархсан нь тэднийг сандаргаж, зарим нь ихээхэн бухимдаж байсныг ойлгож болох” хэмээн бичиж байв.<sup>9</sup>

Линке ийнхүү Монгол Улсын Их Сургуулийн харьяа Гадаад Хэлний Дээд Сургуульд багшлахаар шийдсэн нь ажилдаа тууштай, ихээхэн урам зоригтой орох үүд хаалгыг түүнд нээсэн байна. Хэдийгээр “хангамжийн тогтолцоо нуран унаж”, түүнтэй холбоотойгоор Их сургууль өөрөө төлбөрийн чадваргүй болсны горьг тэрээр мөн л амссан ч гэлээ, “илэн далангүй, найрсаг уур амьсгал”, “туйлын нөхөрсөг хамтын ажиллагаа” түүнийг уужруулж, 8-хан долоо хоногийн дотор бүтэн 5 жилийн хичээлийн хөтөлбөр боловсруулах боломжийг түүнд олгожээ. Ийм нөхцөлд Монгол Улсын Их Сургуулийн Ректор доктор, профессор Д. Дорж, Шинжлэх Ухааны Академийн Ерөнхий нарийн бичгийн дарга, Дрездений Техникийн Их Сургуулийг төгссөн доктор, профессор Ц. Болдсүх нар учир мэддэг, найдвартай түншүүд болгохоо харуулсан байна. Амьдралын нөхцөл байдал ноцтой хүнд байсан ч Линке өмнөө овоорсон үүрэг даалгаврыг биелүүлэхээр шамдаж эхлэв. Тэрээр илтгэлүүдийнхээ нэгэнд:

“Чи сүйрлийн байдалтай байна гэж төсөөлөөд үз, тэгээд түүнээ 10 дахин өсгөөд бодчих ... Давс, элсэн чихэр, цуу, тос гээд наад захын хүнсний зүйлс бараг л олддоггүй байсан даа”

9 Situationsbericht über die Übernahme des Lektorats an der Staatsuniversität Ulan-Bator, 15.01.1991, ДААД-ын архив, Бонн.

хэмээн бичснээс нь үзэхэд түүний амьдрах орчин ямаршуухан байсан нь сэтгэлд буугаад ирнэ.

ДААД монголчуудыг, Германд шинжлэх ухааны ажлыг тэтгэдэг механизмуудтай асар хурдан танилцуулжээ. Монгол эрдэмтдийн хувьд энэ нь цоо шинэ зүйл байв. Социализмын үед олон улсын хамтын ажиллагааны чиглэлд хамгийн наад захын алхам хийхэд хүртэл өөрсдийнх нь ажилладаг яамны зөвшөөрөл шаардлагатай байлаа. Тухайн цаг үеийн гэрч нэгэн эмэгтэй бичихдээ:

“ХБНГУ-ын шинжлэх ухааны болон эрдэмтдийн солилцоог тэтгэдэг байгууллагууд их, дээд сургуулийн эрдэмтэн, судлаачид ямар нэг тусгай зөвшөөрөлгүйгээр ижил төстэй судалгаа хийж буй өөр орны эрдэмтэдтэй хувиараа, шууд харилцаж болно, мөн хоёр талын сонирхол нийлж байвал ийм ажиллагааг ивээн тэтгэдэг сан, хөтөлбөрүүд байдаг гэдгийг идэвхтэй үйл ажиллагаагаараа манай орны эрдэмтдэд ойлгуулсан юм” гэсэн байдаг.<sup>10</sup>

ХБНГУ энэ хүнд үед нь Монголд янз бүрийн салбарт идэвхтэй дэмжлэг үзүүлэхээр шуурхайлан хөдөлсөн юм. Тэдгээрийн нэг нь дээд боловсролын салбар байв. ДААД-ын Ерөнхий нарийн бичгийн дарга доктор Кристиан Боде 1991 оны 4-р сард Гадаад Хэргийн Газраараа дамжуулан Монгол Улсыг ДААД-ын тэтгэлгийн хөтөлбөрт аль болох хурдан, хүндрэл багатайгаар хамруулах талаар тодорхой саналуудыг Монголын талд тавьжээ. Тэрээр албан бичигтээ Монголын тал ч гэсэн өөрийн оронд Германы (тухайлбал Монгол судлалын) оюутнуудыг сургах, эрдэмтдийг нь судалгаа шинжилгээ хийлгэхэд бэлэн байгаагаа илэрхийлснийг ихэд талархан дурдсан байв.

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хооронд хөгжлийн бодлогын хүрээнд хамтран ажиллах тухай 1991 оны 6-р сарын 24-ний Засгийн газар хоорондын хэлэлцээрийн протоколд Монголын талын хүсэлтээр

10 B. Burmaa, Die Zusammenarbeit zwischen der Mongolischen Nationaluniversität und den Universitäten und Hochschulen der BRD, энэ нь: U. B. Barkmann, L. Chajsandaj, Mongolisch-deutsche Beziehungen, Vergangenheit-Gegenwart-Perspektiven, Ulaanbaatar 2004, 335-р талд буй.

юуны түрүүнд улс орны өмнө тулгараад буй эдийн засгийн шинэчлэлд чухал шаарлагатай салбаруудад 10 монгол оюутан сургахаар заажээ.

1991 оны 6-р сарын 26-нд Монгол, Герман хоёр улсын хоорондох соёлын хэлэлцээрийн протоколд гарын үсэг зурав. Уг протоколд гарын үсэг зуран хэрэгжүүлснээр бүр 1991 оны 10-р сарын 3-н гэхэд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, ДААД-ын хооронд хоёр талын хийгээд холбогдох хүрээлэнгийн эрдэмтдийн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор эрдмийн солилцооны хөтөлбөр боловсруулах, эхний ээлжинд жил тутам 5 хүртэл эрдэмтэд солилцохоор харилцан тохирсон байлаа. <sup>11</sup> 1991 оны сүүлээр Германд 500 орчим монгол оюутан суралцаж байсан бөгөөд тэдний 380 нь ДААД-ын жилийн тэтгэлэгт хамрагдаж байв.

ДААД 1992 оны 2-р сард өөрийн хоёр дахь лектор-багш болох хатагтай доктор Барбара Күүнийг хуучин Орос Хэлний Дээд Сургуулийн оронд байгуулагдсан Гадаад Хэлний Дээд Сургуульд илгээжээ. ДААД-ын зэрэгцээ Гёте Институт, Александр фон Хумбольдтын Сан, Карл-Дүйсбүргийн Нийгэмлэг ч бас Монголыг тус тусын тэтгэлгийн хөтөлбөртөө хамруулж эхэлсэн юм.

Германы Дээд Сургуулийн Ректоруудын Бага Хурал хэмээх байгууллагын шинжээчдийн хэсэг 1992 оны 9-р сарын 21-28-ны хооронд Монголд айлчилсан явдал цаашдын хамтын ажиллагаанд онцгой ач холбогдолтой болсон нь дамжиггүй. Шинжээчдийн хэсэг Монголын дээд боловсролын тогтолцооны нөхцөл байдлыг шинжлэн дүгнээд Монгол Улстай хамтран ажиллах зөвлөмж боловсруулжээ. Шинжээчид Монгол Улсын боловсролын тогтолцооны шинэчлэлийг нийт нийгмийн шилжилтийн үйл явцын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзсэн юм. 1990 оныг хүртэл Монголын дээд боловсролын тогтолцоо үндсэндээ Монгол Улсын Их Сургууль, түүнээс ээлж дараагаар салбарлан гарсан 8 дээд сургуулиас бүрдэж байсан бол 1992 он гэхэд 6 коллеж, 15 хувийн

11 Vereinbarung zwischen der Mongolischen Akademie der Wissenschaften und dem Deutschen Akademischen Austauschdienst vom 3. Oktober 1991, ДААД-ын архив, Бонн.

дээд сургуулиас бүтсэн хувийн сектор буй болоод байв. Улсын дээд сургуулиуд санхүүгийн ноцтой хомсдолд орж, мөн хувийн сектор үүссэн нь 1992-93 оны өвлийн семестрээс эхлээд сургалтыг төлбөртэй болгоход зайлшгүй хүргэжээ.

Шинжээчид өөрсдийн судалгаандаа Герман-Монголын шинжлэх ухааны хамтын ажиллагааны тодорхой асуудлуудыг анхааралтай авч үзсэн юм. "ХБНГУ-ын шинэ муж улсуудын дээд сургуулиудад боловсон хүчний томоохон өөрчлөлтүүд хийгдэж байгаагийн улмаас БНАГУ-ын эрдэмтэдтэй тогтоосон хэлхээ холбоо үлэмжхэн тасарсан" нь "гайхах зүйл биш" гэдгийг тэд тэмдэглээд:

"герман хэлийг эзэмшиж, хуучин БНАГУ-ын шинжлэх ухаантай нягт харилцаатай байсан, Монгол Улсын их, дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагуудыг шинээр өөрчлөн байгуулахад чухал үүрэг гүйцэтгэх эрдэмтдэд 'урьдын хэлхээ холбоогоо сэргээх'-ийг зориудаар санал болгох"-ыг шаардсан байлаа.<sup>12</sup>

Тэдний боловсруулсан зөвлөмжид Монголд ажиллаж буй ДААД-ын мэргэжилтэн багш нараар дамжин газар дээрээ хэрэгжих боломжтой саналууд голлох үүрэгтэй орсон байна. Тухайлбал, ДААД-ын Төлөөлөгчийн газрууд дахь герман хэлний хичээлийг бусад дээд сургуулиудын сонирхогч нарт ч нээлттэй болгож, хэл сурах идэвхийг нь эрчимжүүлэхийг зөвлөжээ. Монголын их, дээд сургуулиуд энэ зуур англи хэлийг шинжлэх ухааны анхдагч гадаад хэл болгохоор ихээхэн чармайлт гаргаж байсан үед энэ нь хэрэгжүүлэхэд тун ч амаргүй зорилт байсан юм. Ямартай ч тэр үед ДААД-ын хоёр лектор-багш Монгол орон даяар ямар нэг хэлбэрээр англи хэл зааж байсан Америкийн Энх тайвны корпус (Peace Corps)-ын 60 орчим ажилтныг сөрөн зогсч байлаа. Сургалтыг тэтгэх хэлбэрүүд БНАГУ-ын үетэй харьцуулахад үндсээрээ өөрчлөгджээ. ХБНГУ монголчуудын эхний удаагийн сургалтад тэтгэлэг олгодгоо зогсоож, залуу эрдэмтдийн мэргэжил дээшлүүлэлтэд илүүтэй анхаарах болсон нь юуны өмнө давтан

12 Empfehlungen zur deutsch-mongolischen Hochschulkooperation - Beschluss der Internationalen Kommission der Hochschulrektorenkonferenz, 15. Sitzung am 11. Dezember 1992, ДААД-ын архив, Бонн.

Болон эрдмийн зэрэг хамгаалах сургалтанд хамрагдах боломжийг түлхүү олгоно гэсэн үг байв.

1995 оны 6-р сард ДААД-ын Хятад, Монголын салбарын дарга доктор Удо Хорнбергер монгол түншүүдтэйгээ хамтын ажиллагааны хэтийн төлөвийн талаар санал солилцохоор Монголд ирсэн нь ДААД-ын лектор-багш нарын ажлын үр дүнтэй газар дээр нь танилцах боломжийг түүнд олгожээ. Тэр үед доктор Б.-М. Линке Монгол дахь ажлаа маш амжилттай дуусгаад байсан ба түүний байгуулсан гол гавъяа гэвэл герман хэлний "Foreign Affairs and Service" хэмээх чиглэлийг шинээр бий болгосон явдал байлаа. У. Хорнбергер:

"... аль нэг оронд ажиллаж буй хэн нэг соёлын ажилтныг онцын хохиролгүйгээр өөр хүнээр орлуулах тохиолдол байдаг, харин ДААД-ын лектор-багшийг бол ингэх боломж байхгүй" хэмээн тэмдэглэсэн байдаг.

Гадаад Хэлний Дээд Сургуульд хатагтай доктор Барбара Күүнийн байгуулсан "Германы өдөр тутмын амьдралын номын сан" мөн өндөр сэтгэгдэл төрүүлсэн бөгөөд тэрээр энэ тухайгаа:

"Тэнд байгаа ном, хэвлэлийг хүмүүс маш сайн хүлээн авдаг юм байна. Суудлаасаа олон хүнтэй байдаг энэ номын санд зөвхөн Гётегийн зохиолыг уншаад зогсохгүй, 'Бурда' ("Burda") моодын сэтгүүлээс эхлээд Германы өдөр тутмын амьдралыг харуулсан элдэв ном, хэвлэлтэй танилцах боломжтой юм" гэж бичжээ.

У. Хорнбергер Шинжлэх Ухаан, Боловсролын сайд С. Төмөр-Очиртой чухал яриа хэлцлүүд хийсэн бөгөөд сайд тэгэхэд Б.-М. Линкегийн үйл ажиллагааг өндөр үнэлдгээ ярьсан байв. У. Хорнбергерийн тэмдэглэснээр "тасалгааны температур 10-13 градус байхад" (Монгол Улс тэр үед эдийн засгийн асар хүнд нөхцөлд байсан!) Шинжлэх Ухааны Академийн Ерөнхийлөгч Д. Баатартай хийсэн ярилцлагадаа хоёр түнш юуны өмнө Монголын суралцагчдад сэндвич (sandwich) тэтгэлэг (холимог тэтгэлэг) олгох асуудлаар санал солилцжээ.

1995 онд доктор Барбара Күүнийн халааг авч, хатагтай Зузанне Отто Гадаад Хэлний Дээд Сургуульд ДААД-ын лектор-багшаар ирэв. Тэр жил Эрдмийн Солилцооны Алба Германд суралцаж буй 134 монголчуудыг ивээн тэтгэж байсны 86 нь хуучин БНАГУ-ын тэтгэлэг авагч байсан ба 20 хүнийг тухайн жилийн тэтгэлэгт хамруулсан байлаа.

1996 оны 3-р сард Германы дээд боловсролын тогтолцоо, бүтэцтэй танилцахаар ирсэн Монгол Улсын Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй Монголын боловсролын байгууллагуудын төлөөлөгчдийн айлчлалыг бэлтгэх, зохион байгуулахад ДААД идэвхтэй оролцсон байна.

1997 оны 9-р сарын 16-нд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Монгол Улсын хооронд байгуулсан соёлын хамтын ажиллагааны тухай шинэ хэлэлцээрт Бонн хотноо гарын үсэг зурав. Уг хэлэлцээрээр хэлний сургалтыг өргөтгөх, багш нарыг зуучлан илгээх, эрдэмтэд солилцох, хоёр орны их, дээд сургуулиудын түншлэл, ном хэвлэл солилцох болон бусад салбаруудад хамтын ажиллагааг эрчимжүүлэх шинэ үндэс суурийг тавьсан юм.<sup>13</sup>

1997 онд ДААД Монголын их, дээд сургуулиудын хөтөлбөрт ордог хичээлүүдэд шинэчлэл хийх зорилго бүхий Азийн Хөгжлийн Банкны төсөлд хамрагдах хүсэлт гаргав. Монголын тал уг төслийг ДААД-аар дамжуулан хэрэгжүүлэхийг илүү чухалчилсан байлаа. 20-иод оноос (!) эхэлсэн шинжлэх ухааны уламжлалт сайн харилцаа, Германы их, дээд сургуулиудын сургалтын өндөр түвшин, Зүүн Германы их, дээд сургуулиудыг нийт Германы дээд боловсролын тогтолцоонд интеграцчилах талаар Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хуримтлуулсан их туршлага зэрэг нь үүнд голлох үндэслэл болж өгсөн аж.

Хоёр орны шинжлэх ухааны хамтын ажиллагаа улам бүр амжилттай хөгжиж, үр нөлөө нь нэмэгдсээр байв. ХБНГУ-ын Холбооны Ерөнхийлөгч Р. Херцог 1998 оны 9-р сарын 14-22-ны хооронд Монгол Улсад төрийн айлчлал хийхдээ чухамхүү шинжлэх

13 Udo B. Barkmann (Hrsg.), *Verträge und Abkommen zwischen der Bundesrepublik Deutschland und der Mongolei, Ulaanbaatar 2005*, 79-84-р талууд.

ухааны салбар дахь хамтын ажиллагаанд туйлын эерэг үнэлгээ өгч, Улаанбаатар хотноо болсон нэгэн төрийн хүлээн авалт дээр:

"Соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллаж, түүгээр дамжуулан хувь хүмүүс хоорондоо хэлхээ холбоо тогтоогоогүйсэн бол Герман-Монголын харилцаа өдийд юу болохсон билээ? Чухамхүү энд л хүмүүсийн ойр дотны нөхөрлөл маш өвөрмөц онцгой байдлаар илрэлээ олж байна" хэмээн мэдэгдсэн билээ.<sup>14</sup>

1999 оны 6-р сарын 22-нд ДААД болон Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын яам 1997 оны 9-р сарын 10-ны өдөр хийсэн тохиролцоогоо үргэлжлүүлэн сунгахаар шийдвэрлэв. Шинэ тохиролцоонд Монголын болон гадаадын их, дээд сургууль дүүргэсэн 50 монгол хүнийг Монгол Улсын Засгийн газрын шугамаар (дэлхий даяар нийт 137 монголчууд тэтгэлгээр сурч бийсан) тэтгэлэгт хамруулан Германы их, дээд сургуулиудад илгээхээр заажээ. Эдгээр оюутны асуудлыг ДААД хариуцахаар болсон бөгөөд тэд сургуульд орохын өмнө Улаанбаатар хот, эсвэл Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад хоёр юмуу дөрвөн сарын герман хэлний дамжаанд сууж хэлний бэлтгэл хийдэг байв.<sup>15</sup> Засгийн газрын шугамаар тэтгэлэг хүртэгсдийн сурч байсан зонхилох мэргэжлүүдийг инженерийн чиглэлийн, эрх зүй/ хөдөлмөр/ эдийн засаг, математик хийгээд байгалийн ухаан, хэл, хүмүүнлэгийн ухаан гэсэн дарааллаар жагсааж болно.

1999 оны 9-р сард ДААД Азийн Хөгжлийн Банкны төслийн ажлаа амжилттай дуусгав. Уг төсөл нь "Development and Implementation of a MBA Program", "Curriculum Development, Course Design and Faculty Training in Higher Education", "Higher Education Accreditation", "Establishment of an Education Administration Studies Program" зэрэг дэд хөтөлбөрүүдийг хамарсан маш өргөн хүрээтэй төсөл байлаа. ДААД Монгол дахь боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэх үйлст хамтрагч гол түншийнхээ үүрэг ролийг улам бэхжүүлж чаджээ.

14 Staatsbesuch in der Mongolei, энэ нь: Bulletin, Presse- und Informationsamt der Bundesregierung, Nr. 67, Bonn, den 9. Oktober 1998, 839-р талд буй.

15 Übereinkommen zwischen dem Deutschen Akademischen Austauschdienst und dem mongolischen Ministerium für Bildung, Wissenschaft und Kultur vom 22.06.1999, ДААД-ын архив, Бонн.

ДААД-ын Дэд Ерөнхийлөгч, Пассаугийн Их Сургуулийн Хүндэт Ректор доктор, профессор Полокийн энэ чиглэлээр хийсэн ажлын амжилтыг уг төслийн Монголын талын түншүүд онцгой өндрөөр үнэлдэг юм.

2001 онд ДААД-ын Ерөнхий нарийн бичгийн дарга доктор Х. Бодө Монголд айлчилсан, мөн үеэр Улаанбаатар хотноо Германд төгсөгчдийн уулзалт зохиогдсон явдал ДААД-ын Монголтой явуулж буй хамтын ажиллагаанд хүчтэй түлхэц өгөв. ДААД Монгол дахь үйл ажиллагаагаа үлэмжхэн өргөжүүлжээ. Тус алба Улаанбаатар хотод үндэсний Их Сургууль (өмнө нь Улсын Их Сургууль) болон Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуульд ажиллаж байсан хоёр лектор-багш дээр нэмж өөр багш нарыг урт хугацаагаар томилон ажиллуулахаар шийдвэрлэсэн байв.

Үүний дагуу газар зүйч Михайль Вальтер, монгол судлаач Удо Б. Баркманн нар мөн ондоо багтаж Монгол Улсын үндэсний Их Сургууль (өмнө нь Улсын Их Сургууль)-д урт хугацааны томилолтоор багшилж эхэлсэн юм. В. Вальтер тус Их Сургуулийн Faculty of Earth Sciences-д Center of Mongolian Landscape Research (Molare)-ийг байгуулан Environmental Sciences хэмээх сургалтын шинэ чиглэлийг нэвтрүүлсэн байна. Түүний төлөвлөн зохион байгуулж, удирдан явуулсан экспедицийн ажлууд өөрийнх нь мэргэжлийн салбарт шилжилтийн үеийн хүнд жилүүдэд бараг бүрэн зогсоод байсан туршилтын судалгааг эргүүлэн сэргээхэд ихээхэн хувь нэмэр оруулав.

У. Б. Баркманн үндэсний Их Сургуулийн Center of Mongol Studies-д ажиллаж, Шинжлэх Ухааны Академийн харьяа Олон Улс Судлалын Хүрээлэнгийн дэргэд Герман Судлалын Төвийг байгуулжээ. Хэд хэдэн ном хэвлүүлж, Монголын нэн шинэ үеийн түүх, олон улсын харилцаа, шилжилтийн үйл явцын талаар 45 орчим эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн нь түүний хийсэн эрдмийн ажлын үр дүнг илтгэнэ. Герман Судлалын Төвөөс эрхлэн "Герман: судалгаа, мэдээлэл" сэтгүүлийг монгол хэлээр жилд 2 удаа гаргаж байгаа нь монгол уншигчдыг Герман орон хийгээд Германы эрдэмтдийн Монголын талаарх судалгааны бүтээлүүдийн тухай өргөн цар хүрээтэй мэдээллээр хангаж байна.

2003 оны 7-р сарын 29-нд ХБНГУ-ын Боловсрол, Судалгаа Шинжилгээний яам, Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны яамны хооронд шинжлэх ухаан-технологи, боловсролын талаар явуулах бодлогын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан нь хоёр яамны хариуцсан салбарын хүрээнд явагдаж байсан хамтын ажиллагааг дээд боловсрол хийгээд бусад салбарт үлэмжхэн өргөжүүлэн тэлжээ. Үг хэлэлцээр шинжлэх ухаан-технологийн мэдээлэл, эрдэмтэд солилцох, хамтарсан судалгаа шинжилгээний ажил явуулах, төсөл хэрэгжүүлэх, оюутнууд харилцан сургах ажлыг тэтгэх, хоёр орны их, дээд сургуулиудын хооронд шууд хамтын ажиллагаа тогтоох шинэ шинэ үндэс суурийг тавив.<sup>16</sup>

ХБНГУ бүр 1989 онд "Die Mongolen" ("Монголчууд") хэмээх үзэсгэлэн гаргаснаараа Монголын түүх, соёлыг ихээхэн сонирхдоггоо харуулсан билээ. Мөн 2005 оны 6-р сарын 16-наас 9-р сарын 25-ны хооронд ХБНГУ-ын Боннын Урлагийн үзэсгэлэнгийн Их танхимд ХБНГУ-ын Канцлер, Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор "Чингис хаан ба түүний өв - Монголын Их Эзэнт гүрэн" нэртэй үзэсгэлэн гаргасан нь хоёр орны соёл, шинжлэх ухааны харилцаанд шинэ содон үйл явдал болж чадсан юм. ХБНГУ-ын Канцлер Г. Шрөйдер дээрх үзэсгэлэнд ирүүлсэн мэндчилгээндээ:

"Монголд очсон герман хүн хэн боловч манай орны түүх, өнөөгийн байдлын талаар нарийн ширийн мэдлэгтэй олон хүн тэнд байдгийг мэдэж болно. Тэгвэл Германд Монгол орны тухай мэдлэг төдий л өргөн дэлгэр биш байна" хэмээн онцолсон байв. Ингээд ХБНГУ-ын Канцлер "XIII-XIV зууны лакс монголика (рах mongolica)-гийн үед Монголын Эзэнт гүрэн Европтой хамт соёлын нэг хүрээллийг үүсгэж байсан" хэмээн тэмдэглэжээ.<sup>17</sup>

Уг үзэсгэлэн асар их амжилттай болж, Бонн болон Мюнхений Угсаатны зүйн музейд харгалзан 130.000 буюу 40.000 үзэгчдийг тус тус өөртөө татаж чадсан ба хожим нь Вена, Истанбул хотод мөн

16 U. B. Barkmann (Hrsg.), *Verträge und Abkommen zwischen der Bundesrepublik Deutschland und der Mongolei, Ulaanbaatar 2005*, 111-113-р талууд.

17 *Dschingis Khan und seine Erben. Das Weltreich der Mongolen*, München 2005, 1-р тал.

гарсан юм. ДААД энэхүү үзэсгэлэнг дэмжиж эрдэм шинжилгээний бага хурал (Удо Б. Баркманн) гаргасан төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан бөгөөд уг хурал дээр тавигдсан шинжлэх ухааны илтгэлүүд түүнтэй нэгэн зэрэг явагдсан Германы Судалгааны Нийгэмлэгийн бага хурлын илтгэлүүдийн зэрэгцээ тусгай ном болон хэвлэгдэн гарчээ. ДААД-аас зохион байгуулсан бага хурлын илтгэгчдийн нэг нь Монгол Улсын үндэсний Их Сургуулийн багш, монгол эх бичиг судлаач, нэрт эрдэмтэн доктор, профессор Ш. Чоймаа байсан бөгөөд тэрбээр 1980-1983, 1992-1994 онд Берлиний Хумбольдтын Их Сургуулийн Монгол судлалын ангид монгол хэлний лектор-багшаар ажиллаж байсан билээ.

Монгол Улстай тогтоосон шинжлэх ухааны хамтын ажиллагаа өдгөө ХБНГУ-ын шинжлэх ухааны гадаад харилцааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон нь олон салбарт харагддаг. Нэг талаар ХБНГУ сүүлийн 16 жилийн турш монголчуудын сурах тун дуртай орон хэвээр үлдсэн бөгөөд энэ нь тус орны их, дээд сургуулиуд монголчуудаас сургалтын төлбөр авдаггүй байсантай нь ч холбоотой. Тэр бүү хэл монгол оюутнуудын тоо 2000-2001 оны өвлийн семестрээс эхлээд үлэмжхэн нэмэгдсэн юм. Холбооны Статистикийн Газарт дээрх семестрийн хугацаанд Монголын 972 оюутан бүртгэгдээд байсан бол 2003-2004 оны өвлийн семестр хүртэл Германы их, дээд сургуулиудад сурч буй монгол суралцагчдын тоо бүр 1.400 болтлоо өссөн байна.<sup>18</sup> Ялангуяа хэл, соёл судлал, эрх зүй, эдийн засаг, нийгмийн шинжлэх ухаан, математик, байгалийн шинжлэх ухаан, түүнчлэн инженер-техникийн, өөрөөр хэлбэл, шилжилтийн үеийн Монгол оронд ихээхэн ач холбогдол бүхий чиглэлээр суралцагч монгол оюутнуудын тоо бусдаасаа хавьгүй их байв.

20-иод оны ахмад үеийнхнийхээ нэгэн адил Германд сургууль төгссөн монголчууд өнөөдөр ч гэсэн эх орондоо эргэж ирэхдээ сурч боловсорсон хоёрдогч эх орондоо суралцаж мэдсэн, дадал заншил болгосон, хайрласан бүхнээ “тээшиндээ” хамт авч ирж байна. Герман, Монгол хоёр улс энэ хугацаанд соёлын талаар улам бүр ойртон нягтарсан юм. Пакс монголика-гийн үеэс ялгаатай

18 Statistisches Bundesamt, Ausländische Studenten nach Herkunftsland und Fächergruppe des 1. Studienfachs Mongolei.

нь өнөөгийн Европ болон Монголын нийтлэг соёлын хүрээлэл нь юуны өмнө ардчилал, хүний эрх, эрх зүйт төрийн үнэт зүйлсээр гэдэрдөхөөр болж буй. Үүнд тулгуурласан харилцан ойлголцол, эрүүл ухаан, үнэлэмж нь Clash of Civilizations (Соёл иргэншил хоорондын мөргөлдөөн) үүсэх боломжийг хааж байдаг. "өөрчлөлт шинэчлэлийг өргөн солилцоогоор – Ченж бай Эксченж (Change by Exchange)" гэсэн ДААД-ын гол уриа нэг нь нөгөөгөөсөө суралцах, тэгнээрээ өөрчлөгдөх харилцааны шинэ соёлын илэрхийлэл болж байна.

Германд суралцагч монголчуудын нэлээд нь герман хэлний мэдлэгээ анхлан ДААД-ын лектор-багш нарын ажилладаг Монгол Улсын Их Сургууль болон Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн (өмнө нь Гадаад Хэлний Дээд сургууль байсан) хэлний сургуулиудад олж авсан юм. Ийнхүү тэд нэгэн цагт Монгол Улсын Их Сургуулийн Б.-М. Линке, Кристиане Цильх, Габриеле Планке болон доктор Антье Штрайт, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн доктор Б. Күүнь, Зузанне Отте, Зузанне Бекер, доктор Детлоф Гертнер нарын зэрэг лектор-багш нарын "гараар орсон" байдаг билээ. Тэдний хэн нь ч гэсэн эдгээр оюутнуудад ямар нэг байдлаар "өөрийн гэсэн тамгаа дарж", Герман оронд боловсрол олж авах гэсэн тэдний эрмэлзэлд дэм өгчээ. Он жилүүдийн явцад эдгээр сургуулийн герман хэлний сургалт ихэд чанаржсан юм. Энэ сургуулиудын багшлах бүрэлдэхүүнд олон жилийн өмнө өөрчлөлт хийж, ахмад багш нараа залуу үеийнхнээр сольсон бөгөөд шинэ багш нарын ихэнх нь эдгээр сургуулийн төгсөгчид байв. Герман хэлний сургалтын материал орчин үеийн хэлний хичээлийн шаардлагыг бүрэн хангах болжээ.

Германы их, дээд сургуульд шууд элсэн орох боломж олгодог ТөстДаФ (TestDaF)-ын шалгалтыг хэдэн жилийн өмнөөс эхлэн Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль дээр авдаг болоод байна. Өнөөдөр Монголд герман хэл заадаг их, дээд сургууль хэд хэд бий болоод байгаа юм. Эдгээрээс Монгол Улсын Их Сургууль, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Багшийн Их Сургууль, "Отгонтэнгэр" Их Сургууль, Батлан Хамгаалахын Их Сургууль, "Евро-Ази" Дээд Сургууль, Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийг тус тус дурдах нь зүйтэй.

Энэ дашрамд, Монгол Улсын (үндэсний) Их Сургуулийн Герман хэлний Тэнхимийг олон жилийн турш үр бүтээлтэй удирдаж байгаа доктор, профессор Г. Лувсангийн гавъяаг зориуд онцлон тэмдэглэе. 1975-1980, 1988-1993 онд мөн Берлиний Хумбольдтын Их Сургуулийн монгол хэлний ангид монгол хэлний багшаар ажиллаж байсан, "Герман-монгол толь"-ийн (1981 онд гарсан) хамтран зохиогч доктор, профессор Г. Лувсан бие хүнийхээ хувьд шинжлэх ухааны салбарт хоёр чиглэлд амжилттай хоршин ажиллаж болохыг харуулсан сайн жишээний нэг болох нь лавтай.

Герман бол монголчуудын сурах дуртай орон мөн гэдэг нь өнгөрсөн 16 жилийн хугацаанд ДААД-ын зүгээс монгол оюутнуудыг олноор тэтгэлэгт хамруулсан байдлаас ч харагдана.

**Оюутнууд, эрдмийн зэрэг хамгаалагчдыг ДААД-ын тэтгэлэгт хамруулсан байдал<sup>19</sup>**

	1993	1994	1995	1996	1997	1998/1999	1999/2000
Оюутнууд	2	5	15	1	31	33	14
Зэрэг Хамгаалагчид	35	18	30	29	47	98	108
Нийт	37	23	45	30	78	131	122

**Оюутнууд, эрдмийн зэрэг хамгаалагчдыг ДААД-ын тэтгэлэгт хамруулсан байдал**

	2001	2002	2003	2004	2005
Оюутнууд	9	40	48	54	37
Зэрэг хамгаалагчид	107	72	54	40	54
Нийт	116	112	102	94	91

**Эрдэмтэд, урлагийнхан, захиргааны ажилтнуудыг ДААД-ын тэтгэлэгт хамруулсан байдал<sup>20</sup>**

19 DAAD-Jahresberichte-г үзнэ үү.

20 DAAD-Jahresberichte-г үзнэ үү.

	1993	1994	1995	1996	1997	1998/99	1999/2000
Эрдэмтэд	6	7	12	12	11	26	45
Урлагийнхан/ Захиргааны ажилтнууд	13	15	18	24	21	26	34
Нийт	19	22	30	36	32	52	79

**Эрдэмтэд, урлагийнхан, захиргааны ажилтнуудыг ДААД-ын тэтгэлэгт хамруулсан байдал**

	2001	2002	2003	2004	2005
Эрдэмтэд	15	23	16	32	25
Урлагийнхан/ Захиргааны ажилтнууд	26	29	29	30	26
Нийт	41	52	45	62	51

Нөгөө талаар энэ хугацаанд хоёр орны их, дээд сургуулиудын хооронд эрчимтэй ажил хэргийн харилцаа бий болж, тэр нь судалгааны тодорхой төслүүд, их, дээд сургуулиудын түншлэл зэргээр дамжин хэрэгжиж байна. Эхэн үедээ юуны өмнө Зүүн Германы Их Сургуулиудтай хэрэгжүүлж байсан энэхүү харилцаа өнөөдөр нийт Германыг хамарсан шинжтэй болсон юм. ДААД хотөлбөрүүдийнхээ өргөн боломжийн хүрээнд энэхүү хамтын ажиллагааны аливаа хэлбэрийг дэмжин тэтгэсээр байгаа билээ.

Үүнтэй холбогдуулан янз бүрийн их сургуулиудын хамтын ажиллагааны талаар дурдахгүй өнгөрч болохгүй юм. Тухайлбал, Монгол Улсын Үндэсний Их Сургуулийн биологичид, Халле-Виттенбергийн "Мартин Лүүтер" Их Сургуулийн амьтан судлаачид нэлээд хэдэн төрлийн төсөл дээр хамтран ажиллаад байна. Энэхүү хамтын ажлын хүрээнд "БНМАУ-ын биологийн нөөц" хэмээх хэд хэдэн боть судалгааны ном зэрэг олон бүтээл гарсны дээр дипломын ажил 20, эрдмийн зэрэг горилсон зохиол 10-ыг бичиж амжилттай хамгаалжээ. Халлегийн биологич, доктор, профессор М. Штүббе, түүний монгол талын хамтран зүтгэгч доктор, профессор Н. Даваа нарын зэрэгцээ Монгол Улсын

үндэсний Их Сургуулийн одоогийн Дэд Ерөнхийлөгч, тухайн үедээ Халлед эрдмийн зэрэг хамгаалж байсан доктор, профессор Р. Санжаа Монголын Үндэсний Их Сургууль дахь Герман-Монголын шинжлэх ухааны хамтын ажиллагаанд гарамгай үүрэг гүйцэтгэсэн юм. Тус Их Сургууль 1997 оноос эхлэн Гейттингений Их Сургуулийн Байгаль Хамгаалах Төв (захирал нь доктор, профессор М. Мюленьберг)-тэй ч маш сайн хамтран ажиллаж буй нь үндсэндээ мөн түүний ач гавьяа мөн. Гейттингений Их Сургууль энэ зорилгоор Хонин нугад шинжилгээний станц суурилуулсан байна. Тус Их Сургуулийн Байгаль Хамгаалах Төвтэй тогтоосон хамтын ажиллагааг Орос, АНУ, Польш, Шинэ Зеланд, Австрали, Индонез улсуудын мэргэжил нэгтнүүдийнхээ ажилтай уялдуулан зохицуулсан нь улам бүр олон улсыг хамарсан олон талт хамтын ажиллагааны шинжтэй болж, энэ хооронд Монгол Улсын Үндэсний Их Сургуулийн олон улсын харилцаанд үлгэр дуурайл үзүүлж байгаа билээ.<sup>21</sup>

Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн Гадаад Харилцааны Газрын дарга доктор, профессор Ц. Сарантуяа ихээхэн хичээл зүтгэл гаргасны ачаар тус Их Сургууль олон жилийн өмнөөс Фрайбергийн Уул Уурхайн Академи, Оснабрюкийн Их Сургууль, Дрездений Техникийн Их Сургууль, Дармштадтын Техникийн Их Сургууль, Касселийн Их Сургууль, Аахений Техникийн Их Сургуультай өргөн харилцаатай явж ирэв.

Их, дээд сургуулиудын түншлэл, хамтын ажиллагааны жагсаалтыг энэ мэтчилэн үргэлжлүүлж болох юм. Сүүлийн жилүүдэд эдгээр их, дээд сургуулийн хамтын ажиллагаа эрдэмтэд солилцохын зэрэгцээ шинжлэх ухааны тодорхой төслүүдийг хэрэгжүүлэхэд илүү төвлөрч байгааг онцлон дурдах хэрэгтэй.

Герман-Монголын шинжлэх ухааны хамтын ажиллагааны нэг онцгой чухал төсөл бол 1997 онд Бонны монгол судлаач доктор, профессор К. Загастерийн санаачилсны дагуу эртний Монголын нийслэл Хархорумын "Хааны ордны дүүрэг"-т хийсэн малтлага юм.

21 У. Б. Баркманн, Б. Бурмаа, МУИС ба Германы их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, *Зууны мэдээ*, 2002.10.01

ХҮНГУ-ын Холбооны Ерөнхийлөгч Р. Херцог Монгол Улсад төрийн айлчлал хийж буйг тохиолдуулан Монгол-Германы хамтарсан Хархорумын экспедицийн хамтын ажиллагааны гэрээнд 1998 оны 9-р сарын 18-ны өдөр Хархорумд гарын үсэг зуржээ. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн Хүрээлэн, Германы Археологийн Хүрээлэнгийн Ерөнхий ба Харьцуулсан Археологийн Комиссын зэрэгцээ Бонны Их Сургуулийн Нэн эртний ба Түүрүү үеийн Түүхийн Археологийн Хүрээлэн энэхүү малтлагад мөн оролцсон байна. Холбооны Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхийлөгч нар 2000 оны 5-р сарын 30-ны өдөр гаргасан хамтарсан Мэдэгдэлдээ, "Энэхүү төслийг Монгол Улсын түүх, археологийн салбар дахь олон улсын хамтын ажиллагааны хувьд ихээхэн ач холбогдолтой хэмээн үзэж, Герман-Монголын харилцааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор" <sup>22</sup> өөрсдийн ивээлд авсан билээ. ДААД энэ чухал төслийг эхний мөчөөс нь эхлэн тэтгэлгийн хөтөлбөрүүдийнхээ хүрээнд боломжийн хэрээр дэмжиж ирлээ. Тухайлбал, малтлагын цэг дээр Монголын залуу археологичдод нарны гэрлээс хамгаалах сэдвээр зуны сургалт явуулах, археологийн салбарт эрдмийн зэрэг горилогч монголчуудад тэтгэлэг олгох зэргээр ажиллаж байв.

Мөн ДААД-ын дэмжлэгтэйгээр жил бүр зохион явагддаг "Туурайн төвөргөөн" хөгжмийн наадам (Roaring Hoofs Festival)-ыг энд мөн дурдах нь зүйтэй. Уг арга хэмжээ доктор, профессор Бернхард Вүлфф (Брайсграу дахь Фрайбүргийн Хөгжмийн Дээд Сургууль)-ийн гарамгай авъяас билэг, хичээл зүтгэлийн ачаар Монголын хөгжмийн урлагийн зуны хөтөлбөрт онцгой содон үйл явдал - Highlight болон хөгжсөн юм. Б. Вүлфф энэхүү наадмыг зохион байгуулснаараа орчин үеийн болон уламжлалт хөгжим, байгалийн гоо сайхныг торгон мэдрэмжтэйгээр хослуулан "хөгжмийн зохиол болгож" чадсан бөгөөд хөгжмийн ийм төрөл Монголд л лав үгүйлэгдэж байдаг нь лавтай.

Монголын их, дээд сургуулиуд ДААД, түүний төлөөлөгчдийн үйл ажиллагааг өндрөөр үнэлсэн юм. Ийнхүү Монгол Улсын

<sup>22</sup> H.-G. Hüttel, энэ нь: Expeditionen in vergessene Welten. 25 Jahre Archäologische Forschungen in Afrika, Amerika und Asien, = AVA-Forschungen, B d. 10, Aachen 2004, 179-р талд буй.

үндэсний Их Сургууль ДААД-ын Ерөнхийлөгч доктор, профессор Т. Берхэмд, Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль ДААД-ын Ерөнхий нарийн бичгийн дарга доктор Кристиан Бодед "Хүндэт доктор" цолыг тус тус олгосон билээ. Монголын олон оюутан, докторантууд ДААД-ын Хятад, Монголын салбарын дарга асан, харамсалтайгаар эрт хорвоог орхисон доктор Удо Хорнбергерийг онцгой хүндэтгэн дурсаж явдаг бөгөөд Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль түүнд "өргөмжлөлт профессор" цол хүртээж байв.

ДААД, Монголын хамтын ажиллагаа нь Монгол талын олон олон хамтран зүтгэгч, ДААД-ын клуб, тэрчлэн Германд сургууль төгсөж ирэгсдийн "Монгол-Герман гүүр" хэмээх байгууллагын бүтээлч туслалцаагүйгээр ийм их амжилтад хүрэх боломжгүй байсан юм.

Энэ дашрамд цэл залуугаараа ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн, эхэн үедээ Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Ерөнхий нарийн бичгийн дарга, хожмоо үндэсний Их Сургуулийн Дэд Ерөнхийлөгч асан, цуцалтгүй хөдөлмөрч доктор, профессор Ц. Болдсүхийг онцгой хүндэтгэн дурсъяу.